| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,900,000.00          | 4,750,000.00          | 96.94%         |
| 210807 | Газрын төлбөр  | 200,000.00            | 80,700.00             | 40.35%         |
| 2201   | Бараа үйлчилгээний бусад зардал                          | <b>540,000.00</b>     | <b>540,000.00</b>     | <b>100.00%</b> |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 540,000.00            | 540,000.00            | 100.00%        |
|        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>47,955,500.00</b>  | <b>47,595,500.00</b>  | <b>99.25%</b>  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                   | 47,955,500.00         | 47,595,500.00         | 99.25%         |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж         | 47,595,500.00         | 47,595,500.00         | 100.00%        |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал                          | 360,000.00            | -                     | -              |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>688,604,600.00</b> | <b>662,435,920.57</b> | <b>96.20%</b>  |
| 1310   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | <b>640,649,100.00</b> | <b>614,480,420.57</b> | <b>95.92%</b>  |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих                                  | 640,649,100.00        | 614,480,420.57        | 95.92%         |
| 122    | <b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>                 | <b>47,955,500.00</b>  | <b>47,955,500.00</b>  | <b>100.00%</b> |
| 122005 | Улсын төсвөөс санхүүжих                                  | 47,955,500.00         | 47,955,500.00         | 100.00%        |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| ДАНС   | ҮЗҮҮЛЭЛТ                             | төгрөгөөр     |               |       |
|--------|--------------------------------------|---------------|---------------|-------|
|        |                                      | төлөвлөгөө    | ГҮЙЦЭТГЭЛ     | Хувь  |
| 21     | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12 |
| 210    | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                   | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12 |
| 2101   | Бараа, үйлчилгээний зардал           | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12 |
| 210102 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил    | 40,141,104.66 | 38,514,261.24 | 95.95 |
| 2102   | Нэмэгдэл                             | 40,141,104.66 | 38,514,261.24 | 95.95 |



Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|        |  |               |               |        |
|--------|--|---------------|---------------|--------|
| 210201 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,420,912.83  | 3,647,718.62  | 56.81  |
| 210202 | Тэтгэврийн даатгал                             | 4,558,784.19  | 2,484,770.10  | 54.51  |
| 210203 | Тэтгэмжийн даатгал                             | 472,660.00    | 292,325.91    | 61.85  |
| 210204 | ҮОМШӨ ний даатгал                              | 296,864.91    | 158,872.88    | 53.52  |
| 210205 | Ажилгүйдлийн даатгал                           | 121,863.75    | 142,349.91    | 116.81 |
| 2201   | Эрүүл мэндийн даатгал                          | 970,739.98    | 569,399.82    | 58.66  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                | 30,289,100.00 | 29,405,180.00 | 97.08  |
|        | Бараа үйлчилгээний бусад зардал                | 30,289,100.00 | 29,405,180.00 | 97.08  |
| 1311   | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                 | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12  |
| 131103 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                        | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12  |
|        | Улсын төсвөөс санхүүжих                        | 76,851,117.49 | 71,567,159.86 | 93.12  |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь бүртгэлийн ангиллыг тогтоох, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх, түүнчлэн улсын бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, төрөл, мэдээллийн нэгдсэн сан, улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын бүртгэлийг хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах үүрэгтэй Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тайлант онд 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлж, 100.00 хувийн гүйцэтгэлтэй хэмээн тайлагнасныг аймгийн Засаг даргын Б/67 дугаар захирамжаар биелэлтийг 94.7 хувийн, үнэлгээг 93.25 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

2024 оны нийт төлөвлөгдсөн зардлын санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөө 688,604.6 мянган төгрөг, гүйцэтгэл 688,604.6 мянган төгрөг буюу гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 240 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол ;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол "Автомашин ашиглалтын тухай";
- Сангийн сайдын 2024 оны 52 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай",

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг газрын даргын тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул байгууллагын дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар түүнийг аудитад ашиглахгүй гэж үзлээ.



Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны хувьд Хөдөлмөрийн тухай хууль, болон бусад хуулиудад нийцүүлэн гарсан дээд шатны байгууллагуудын тогтоол, журам, тушаал, шийдвэрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа даргын тушаалаар тухай бүрд нь өөрчлөлт оруулан мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй ба нягтлан бодогч өөрчлөгдөж, хэлтсийн даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Б/9 тоот тушаалаар П.Насанжаргал томилогдсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж байгаа нь зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,943.6 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт        |
|--|-------------------|--------------------|-----------------|
| Б  | 1                 | 2                  | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                               | 1,579.4           | 468.6              | -1,110.8        |
| Бараа материал                               | 20,442.4          | 22,319.5           | 1,887.1         |
| Авлага                                       | 0,0               | 786.6              | 786.6           |
| Үндсэн хөрөнгө                               | 178,047.0         | 169,540.5          | -8,506.5        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>200,068.8</b>  | <b>193,125.2</b>   | <b>-6,943.6</b> |
| Өглөг  | 473.0             | 9,329.7            | 8,856.7         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 199,595.8         | 183,795.5          | -15,800.3       |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>200,068.8</b>  | <b>193,125.2</b>   | <b>-6,943.6</b> |

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,110.8 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангаас зарцуулалт хийсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 1,887.1 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан бараа материалтай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 786.6 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн урьдчилгааг хэт өндөр өгсөн нь авлага үүсэхэд нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 8,506.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдэлтэй холбоотой;
- Өглөг өмнөх оноос 8,856.7 мянган төгрөгөөр өссөн нь аудитын төлбөр 1062.0 мянга, Анар үйлс ХХК-д хангамжийн бараа материалын материалын өглөг 1,769.3 мянга, цалин хөлсний 6,025.4 мянган төгрөгийн зардалтай холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ өнгөрсөн оноос 15,800.3 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дүнд нөлөөлсөн;
- Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн 6,943.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дүнгийн бууралттай холбоотой;

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,169.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 2024 онд 502,537.4 мянган төгрөгөөр баталсныг тодотголоор 688,604.6 мянган төгрөг буюу 186,067.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Энэ нь Засгийн газрын 128 дугаар тогтоол, УБЕГ-ын



даргын 2024 оны А/164 дугаар тушаалаар хоол, унааны нөхөн олговор шинэчилсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 662,435.9 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 96.1 хувийг зарцуулж, 26,528.7 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлбэл:

| Д/д         | Үзүүлэлт  | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү           |
|-------------|---|------------------|------------------|-----------------|
| 1           | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил               | 470,991.1        | 470,991.1        | 0.0             |
| 2           | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл  | 100,634.0        | 79,874.1         | 20,759.8        |
| 3           | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал       | 50,300.0         | 45,847.1         | 4,452.8         |
| 4           | Хангамж, бараа материалын зардал                | 11,194.0         | 11,182.8         | 11.1            |
| 5           | Эд хогшил худалдан авах                         | 1,800.0          | 1,574.5          | 225.5           |
| 6           | Томилолт, зочны зардал                          | 90.0             | 0.00             | -90.0           |
| 7           | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 5,100.0          | 4,830.7          | 269.3           |
| 8           | Бараа үйлчилгээний бусад зардал                 | 540.0            | 540.0            | 0.0             |
| 9           | Бусад урсгал шилжүүлэг                          | 48,315.5         | 47,595.5         | 720.0           |
| <b>НИЙТ</b> |   | <b>688,964.6</b> | <b>662,435.9</b> | <b>26,528.7</b> |

Зардлын хэмнэлтэд төсвийн хуваарилалт буюу төлөвлөлт гол нөлөөлөл үзүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 54,886,1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосныг зохих журмын дагуу зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тусгай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй болон харьцуулсан үнийн тендер зарлах төсөл батлагдаагүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Б.Бямбадорж, чанарын менежер Г.Цогтбаатар нар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 551,340.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 8,270.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь 2024 онд зарим эрх зүйн актуудад өөрчлөлт орсонтой холбоотой. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 820,088.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, материаллаг байдлыг 12,301.3 мянган төгрөгөөр тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 36 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөж, хяналтыг хэрэгжүүлэв. Байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.



Хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтийг авч үзэхэд нийт урсгал зардал 26,528.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 166,548.7 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журмын 3 дугаар зүйлийн 3.2.10 заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Үндэсний аудитын газраас зарласан сонгон шалгаруулалтаар Говьсүмбэр аймгийн багц 1-д тэнцэж, гурвалсан гэрээг 2024 оны 9 дүгээр сарын 24-нд байгуулж, аудитын нээлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай шалгагдагч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдыг оролцуулан хийв.

Завсрын аудитыг эхний 9 сарын санхүүгийн болон холбогдох баримт, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажилбаруудыг гүйцэтгэж, илэрсэн алдаа, зөрчлийн асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулж, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан.

Асуудлын бүртгэлийг жилийн дүнгээр нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/155 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |             | Биелэлт  |             |              |
|-----------------|------------------------|-------------|----------|-------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн         | Тоо      | Дүн         | Хувь         |
| Акт             | -                      | -           | -        | -           | -            |
| Албан шаардлага | -                      | -           | -        | -           | -            |
| Зөвлөмж         | 1                      | 0,00        | 1        | 0,00        | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>0,00</b> | <b>1</b> | <b>0,00</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,452.6 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

1. Тэтгэврийн 2 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг 2024 оны 4-9 саруудад 2,252.5 мянган төгрөг дутуу суутган тооцсон;
2. УИХ-ын сонгуулийн санхүүжилтийн орлогыг 883.9 мянган төгрөгөөр бууруулан, төсөвт буцаан төвлөрүүлсэн шилжүүлгийн зардлын ангиллыг буруу сонгож бүртгэсэн;
3. Нийгмийн даатгалын тайланд 4 ажилтны нэр болон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүлэн тайлагнасан;
4. Улсын төсвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтээс буцаан төвлөрүүлэлтүүдийн 31,452.6 мянган төгрөгийн залруулах бичилтүүдийг хийж тайлагнаагүй

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага өгөөгүй.

### 5.3 Зөвлөмж өгөөгүй.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |         | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |         | Үүнээс     |         |              |     | Зөвлөмж |     |
|---|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
|   |            |         |                                   |     |                          |         | Залруулсан |         | Залруулаагүй |     |         |     |
|   | Тоо        | Дүн     | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн     | Тоо        | Дүн     | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Тэтгэврийн 2 ажилтны НДШ дутуу суутган тооцсон              | 1          | 2,252.5 |                                   |     | 1                        | 2,252.5 | 1          | 2,252.5 |              |     |         |     |
| УИХ-ын сонгуулийн санхүүжилтийн орлогыг төсөвт төвлөрүүлэхд | 1          | 883.9   |                                   |     | 1                        | 883.9   | 1          | 883.9   |              |     |         |     |

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|  |   |          |  |  |   |          |   |          |  |  |   |     |
|--|---|----------|--|--|---|----------|---|----------|--|--|---|-----|
| Эз ангиллыг буруу сонгож бүртгэсэн   |   |          |  |  |   |          |   |          |  |  |   |     |
| НД-ын тайланд 4 ажилтны нэр, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүлэн тайлагнасан  | 1 | 0,0      |  |  | 1 | 0,0      | 1 | 0,0      |  |  |   |     |
| Улсын төсвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтээс буцаан төвлөрүүлэлтүүдийн 31,452.6 мянган төгрөгийн залруулах бичилтүүдийг хийж тайлагнаагүй | 1 | 31,452.6 |  |  | 1 | 31,452.6 | 1 | 31,452.6 |  |  |   |     |
| Дүн  | 4 | 34,589.0 |  |  | 4 | 34,589.0 | 4 | 34,589.0 |  |  | - | 0.0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган

төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|   |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|   | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 166,548.7 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй | 1           | -   | -             | -   | -               | -   | 1       | -   |
| Дүн   | 1           | -   | -             | -   | -               | -   | 1       | -   |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ААБ 6.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс  
Байгууллагын РД: 4611462

Аудитын код: ГСА-2025028НА-СТА-ТШЗ  
Аудитын нэр: Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс  
Тайланг хугацаа: 2024.01.01-2024.12.31

| №   | Ажил гүйцэтгэний ажил, дансны үндэсдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн /Төгрөгөөр/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн харуу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний |                              |
|---|---|--|------------------------|---------------------------------------|--|--|-----------------|---|------------------------------|
|   |   |  |                        |                                       |  |  |                 | Албан тушаал                            | Овог нэр                     |
| <b>A</b>  | <b>1</b>  | <b>2</b>   | <b>3</b>               | <b>4</b>                              | <b>5</b>                               | <b>6</b>                                   | <b>7</b>        | <b>8</b>                                | <b>9</b>                     |
| <b>1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл</b>  |   |  |                        |                                       |  |  |                 |   |                              |
| 1   | Цалин   | Тэтгэрийн 2 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг 2024 оны 4-9 саруудад дугуу суутган тооцсон  | 2,252,500.0            | Залруулга                             | зөвшөөрсөн                             | Залруулга                                  | Залруулга       | Дарга<br>нягтлан бодогч                 | З.Баяндугар<br>П.Насанжаргал |
| 2   | Зардал  | УИХ-ын сонгуулийн санхүүжилтийн орлогыг 883.9 мянган төгрөгөөр бууруулан, төсөөт буцаан төвлөрүүлсэн шилжүүлгийн зардлын ангиллыг буруу сонгож бүртгэсэн | 883,920.0              | Залруулга                             | зөвшөөрсөн                             | Залруулга                                  | Залруулга       | Дарга<br>нягтлан бодогч                 | З.Баяндугар<br>П.Насанжаргал |
| 3   | Зардал  | Нийгмийн даатгалын тайланд 4 ажилтны нэр болон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүлэн тайлагнасан.   | -                      | Залруулга                             | зөвшөөрсөн                             | Залруулга                                  | Залруулга       | Дарга<br>нягтлан бодогч                 | З.Баяндугар<br>П.Насанжаргал |
| 4   | Төсвийн гүйцэтгэлийн тайлан                       | Улсын төсвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтээс буцаан төвлөрүүлэлтүүдийн 31,452.6 мянган төгрөгийн залруулах би-чилтүүдийг хийж тайлагнаагүй            | 31,452,637.1           | Залруулга                             | зөвшөөрсөн                             | Залруулга                                  | Залруулга       | Дарга<br>нягтлан бодогч                 | З.Баяндугар<br>П.Насанжаргал |
|   |   |  | <b>Дүн</b>             |                                       |  |  |                 |   |                              |
|   |   |  | <b>34,589,057.1</b>    |                                       |  |  |                 |   |                              |
| <b>2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл</b> |   |  |                        |                                       |  |  |                 |   |                              |
| <b>Дүн</b>  |   |  |                        |                                       |  |  |                 |   |                              |
| <b>3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл</b>                       |   |  |                        |                                       |  |  |                 |   |                              |
| 1   | Шилэн данс  | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 166,548.7 мянган төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцорсон   | -                      | Зөвлөмж                               | зөвшөөрсөн                             | Зөвлөмж                                    | Зөвлөмж         | Дарга<br>нягтлан бодогч                 | З.Баяндугар<br>П.Насанжаргал |
|   |   |  | <b>Дүн</b>             |                                       |  |  |                 |   |                              |
|   |   |  | <b>34,589,057.1</b>    |                                       |  |  |                 |   |                              |

Бэлтгэсэн: Батгалгаат тооцоолол, аудит, ХХ-ийн  
Захирагч *М.Буянбулган* М.Буянбулган Огноо:  
Ханасан, Аудитын менежер *С.Наранбаяр* С.Наранбаяр Огноо:  
Ханасан, Дарга *Б.Сарантуяа* Б.Сарантуяа Огноо:

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн  
Дарга *З.Баяндугар* З.Баяндугар  
Нягтлан бодогч *П.Насанжаргал* П.Насанжаргал  
ГСТ7460 3223010003  
4611462

42171-4454  
УСА0055 9019049